

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан .....	4
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	8
2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудад хийсэн аудитын дүнгийн талаар.....	8
2.8.3 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	9
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ...	9
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.11 Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Менежментийн захидал.....	12
3.1 Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоо .....	12
3.2 Бараа материалын зарцуулалт .....	13
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	18
5. Хавсралт.....	19
5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар
УЦУОШТ	Ус цаг уур, орчны шинжилгээний төв
УЦУОСМХ	Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ЦАГ УУР, ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГА С.ЭНХТҮВШИН ТАНАА

2019.03.25 № 01/566  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цаг уур, орчны шинжилгээний газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Е.ОЮУНБИЛЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч С.Энхтүвшин танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 05-наас 03 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Болормаа, Э.Энхбаатар нар хэрэгжүүлэв.

Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/146 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.



### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Цаг уур, орчны шинжилгээний газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Цаг уур, орчны шинжилгээний газар нь “Ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ хийж, бодит болон урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдлээс сэрэмжлүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Цаг уур, орчны шинжилгээний газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын хэмжээнд ус цаг уур, байгаль орчны төлөв байдал, чанарын хяналт шинжилгээг зохион байгуулж, хэрэглэгчийг мэдээллээр шуурхай хангах, ус, цаг агаарын аюултай үзэгдлийн улмаас үүсч болзошгүй гамшгийн эрсдэлээс эртнээс сэрэмжлүүлэх;
- Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг нэгдсэн удирдлага, нэгдмэл арга зүйгээр хангах, өргөжүүлэх, чадавхийг бэхжүүлэх;
- Ус цаг уур, байгаль орчны чанарын хяналт шинжилгээний улсын сүлжээний үйл ажиллагааг тасралтгүй явуулж, мэдээлэл цуглуулах, түүнийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх техникийн найдвартай ажиллагааг хангах, техник технологийн байнгын шинэчлэл хийх;
- Ус, цаг уур, байгаль орчны архив, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх ажлыг удирдан зохион байгуулах, хэрэглэгчдэд мэдээллээр үйлчлэх.

Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Цаг уур, орчны шинжилгээний газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Цаг уур, орчны шинжилгээний газар нь нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Цаг уур, орчны шинжилгээний газрын Дотоод аудитын алба харьяа 2 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийжээ. Аудитаар нийт 1,253.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 11.1 сая төгрөгийн 8 төлбөрийн акт, 73.1 сая төгрөгийн

зөрчлийг арилгах 9 албан шаардлага, 94.7 сая төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, 1,074.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулж ажиллажээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Цаг уур, орчны шинжилгээний газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2018 оны нийт зардал 24,647.6 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 246.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд сонгосон хувийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.



Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 26 байгууллага, нэгжийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулахаас 15 байгууллага аудитад хамрагдсан байна.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	15	4	7	0
	<b>Дүн</b>	15	4	7	0

Адитад хамрагдсан төсвийн шууд захирагчдын 15 санхүүгийн тайлангаас “Зөрчилгүй” 14, “Хязгаарлалттай” 1 санал дүгнэлт авснаас 1 санхүүгийн тайланд гэрээгээр аудит хийлгэсэн байна.

### 2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 99.5 хувь буюу 8,890.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 0.1 хувь буюу 4.8 сая төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 0.2 хувь буюу 13.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 0.22 хувь буюу 30.1 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

/сая төгрөг/

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	24	42.0	8	4.8	3	13.6	13	23.6				
2	ТТЗ	2	6.5					2	6.5				
	<b>Дүн</b>	<b>26</b>	<b>48.5</b>	<b>8</b>	<b>4.8</b>	<b>3</b>	<b>13.6</b>	<b>15</b>	<b>30.1</b>				

### 2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудад хийсэн аудитын дүнгийн талаар

Архангай, Баянхонгор, Дундговь, Орхон, Дархан-Уул, Сүхбаатар аймгуудын УЦУОШТ-д томилолтын зардал, цалин, цалингийн нэмэгдэл илүү бодож олгосон, зориулалтын бус зардал гаргасан зэрэг зөрчилд төлбөрийн акт тогтоож, Дорноговь, Дундговь, Увс аймгуудын УЦУОШТ-д цалин дутуу бодож олгосон, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ бүртгэсэн, замын хуудас хөтлөөгүй шатах тослох материал олгосон зэрэг зөрчилд албан шаардлага хүргүүлж, Баянхонгор,

Дорнод, Сүхбаатар, Дархан-Уул, Орхон аймгуудын УЦУОШТ болон УЦУОСМХ зэрэг байгууллагад аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх хугацаанд ЦУОШГ, Нислэгийн цаг уурын төв, Улаанбаатар хотын УЦУОШГ, Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн 2018 оны санхүүгийн тайланг түүвэрт хамрууллаа.

Аудитаар материаллаг хэмжээний алдаа, зөрчил илрээгүй болно.

### **2.8.3 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 15 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд тусгаж, бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### **Асуудал 1: Санхүүгийн нэгтгэсэн тайлан**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэж, тайлагнаагүй байна.

Шийдэл: Аудитын явцад залруулсан

#### **Асуудал 2: Санхүүгийн тайлангийн залруулга**

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт 8,864.9 сая төгрөгийг цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант үеийн үр дүн дансанд тайлагнасан байна.

Шийдэл: Аудитын явцад залруулсан.

### **2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Цаг уур, орчны шинжилгээний газрын Орчны шинжилгээний хэлтсийн 8 орон тоо, холбогдох цалингийн санг 2019 оны төсвөөс хасаж баталсан боловч БОАЖС-ын 2019 оны А/60 дугаар тушаалын дагуу Орчны шинжилгээний хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэнг өмнөх албан тушаалд буцаан томилсон

байна. Үүний дагуу дараагийн аудитаар бүтэц, орон тоо, цалингийн сангийн зарцуулалтыг хянаж үзэх.

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хянаж үзэхэд төлөвлөгөөнд тусгагдаагүй 310.6 сая төгрөгийн худалдан авалт нэмэгдсэнээс УБ хотын УЦУОШТөвийн байрны дулаан хангамжийг цахилгаан халаалтад шилжүүлэх, эко ариун цэврийн байгууламж суурилуулах ажлын 180.0 сая төгрөгийн тендер зарлагдаж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан боловч санхүүжилт шилжүүлээгүй шалтгаанаар гэрээний хугацаанд ажил хийгдээгүй байна.

## **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Цаг уур, орчны шинжилгээний газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой тайлант онд 5 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 22,418.2 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 22,350.6 сая төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

Төсвийн орлого, зардлын төлөвлөгөөний биелэлтийг харьяа байгууллагаар нь авч үзвэл Нислэгийн цаг уурын төв өөрийн орлого 24.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 14.4 сая төгрөг төвлөрүүлж орлогын төлөвлөгөө 9.6 сая төгрөгөөр тасарсан нь Таван толгой нисэх буудлын үйл ажиллагаа 2015 оноос зогссонтой холбоотой байна. Мөн тус төвийн зардлын төсөв 865.9 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 830.1 сая төгрөг буюу 35.8 сая төгрөгийн хэмнэлттэй тайлагнасан нь Хөшигийн хөндийн шинэ нисэх буудал ашиглалтанд ороогүйгээс байрны түрээс, гэрэл цахилгааны зардал хэмнэгдсэн байна.

## **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Шилэн дансны веб сайтад төсөв/гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн оруулсан боловч хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт болон бусад мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5 зөвлөмж, 2 албан шаардлагын биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Цаг уур, орчны шинжилгээний газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББООС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Цаг уур, орчны шинжилгээний газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй, анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоо**

##### **3.1.1 Илрүүлэлт**

Тайлант онд эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт 2.8 сая төгрөгөөр тооцоо нийлсэн боловч санхүүгийн тайланд авлагаар тайлагнаагүй байна.

Мөн баярын өдрүүдээр ажилласан цагийн тооцоог олгосон цалингийн нэмэгдэлтэй тулган шалгахад шинэ жилийн баярын өдрөөр ажилласан 103 цагийн тооцоо гарсан боловч 111 цагаар буюу 8 цаг илүү бодож нэмэгдэл цалин олгосон байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэн зарчмыг баримталж нягтлан бодох бүртгэлийг хөтлөх

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.



## **3.2 Бараа материалын зарцуулалт**

### **3.2.1 Илрүүлэлт**

Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх пуужингийн зарцуулалт 9ш пуужин буюу 3.7 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Пуужингийн зарцуулалтыг харвалтын тайлантай тулган шалгахад 9 пуужин харвасан акт дутуу байгаа нь Улаанбаатар хотын экспедицийн харвасан бш пуужингийн акт дутуу, зарим аймгууд шаардлага хангахгүй пуужинг үлдэгдлээр тоолдог, эсвэл зарцуулсанд тооцдог зэргээс 3ш пуужингийн зөрүү гарсан байна.

### **3.2.2 Эрсдэл:**

Холбогдох хууль тогтоомжийн заалт хэрэгжихгүй байх

### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,880,290.7	4,522,111.8
МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,179.9	8,961.5
АВЛАГА	36,117.4	25,986.6
УРЬДЧИЛГАА	15,267.1	0.0
БАРАА МАТЕРИАЛ	4,817,726.3	4,487,163.7
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,060,098.6	21,958,352.6
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,060,098.6	21,958,352.6
Биет хөрөнгө	8,970,695.8	13,180,576.4
Биет бус хөрөнгө	89,402.8	8,777,776.2
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	13,940,389.3	26,480,464.4
НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,821.1	75.4
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,821.1	75.4
Өглөг	15,821.1	75.4
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,924,568.2	26,480,389.0
Засгийн газрын хувь оролцоо	13,924,568.2	26,480,389.0
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	16,805,984.8	25,670,935.4
Хуримтлагдсан үр дүн	-4,521,928.9	-3,998,337.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,640,512.3	4,807,790.6
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	13,940,389.3	26,480,464.4

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлан он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	27,332,418.5	26,152,908.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,309,062.6	2,383,820.9
Нийтлэг татварын бус орлого	4,309,062.6	2,383,820.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,023,356.0	23,769,087.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	25,923,231.7	24,647,654.1
УРСГАЛ ЗАРДАЛ	25,893,799.8	24,647,654.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,702,838.2	24,300,628.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,960,803.4	16,389,884.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,758,927.6	1,978,266.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	707,492.1	740,632.9
Хангамж, бараа материалын зардал	551,257.3	686,385.4
Нормативт зардал	34,842.4	40,004.8
Эд хогшил, урсгал засварын зардал	1,747,646.6	550,362.7
Томилолт, зочны зардал	225,77.0	194,949.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,020,107.0	1,205,489.9
Бараа үйлчилгээний бусад зардал	2,685,884.9	2,514,652.3
ХҮҮ		
ТАТААС		
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,190,961.6	347,025.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,431.9	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,409,186.8	1,505,254.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	307.5	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	713,485.4	982,831.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	696,008.9	522,422.8

#### 4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	23,329,832.5	23,811,786.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	67,159.9	81,095.9
Нийтлэг татварын бус орлого	67,159.9	81,095.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,262,672.6	23,730,690.6
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,167,095.7	23,595,500.1
УРСГАЛ ЗАРДАЛ	23,167,095.7	23,595,500.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,856,643.6	23,216,592.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,959,932.8	16,391,005.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,750,626.1	1,959,338.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	724,284.4	742,802.2
Хангамж, бараа материалын зардал	391,349.0	454,607.8
Нормативт зардал	53,971.3	60,112.0
Эд хогшил, урсгал засварын зардал	1,729,413.5	2,300,046.3
Томилолт, зочны зардал	228,337.5	204,451.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	747,939.5	950,270.2
Бараа үйлчилгээний бусад зардал	270,789.4	153,958.5
ТАТААС		
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,310,452.1	378,907.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	162,736.8	216,286.3
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	168,456.7	218,504.7
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	168,456.7	218,504.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	168,456.7	218,504.7
Дотоод эх үүсвэрээр	168,456.7	218,504.7
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-168,456.7	-218,504.7
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-5,719.9	-2,218.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,899.8	11,179.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,179.9	8,961.5

#### 4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/ өмч
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,229,741.2	0.0	13,229,741.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	12,272.3	0.0	12,272.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,242,013.5	0.0	13,242,013.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-13,454.2	0.0	-13,454.2
Тайлант үеийн үр дүн	696,008.9	0.0	696,008.9
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,924,568.2	0.0	13,924,568.2
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	13,924,568.2	0.0	13,924,568.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,169.1	0.0	1,169.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,925,737.3	0.0	13,925,737.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	12,032,228.9	0.0	12,032,228.9
Тайлант үеийн үр дүн	522,422.8	0.0	522,422.8
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,480,389.0	0.0	26,480,389.0



#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,418,244.3	22,350,654.3	67,590.0	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,418,244.3	22,350,654.3	67,590.0	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,259,218.8	22,205,691.5	53,527.3	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,104,639.7	16,102,025.0	2,614.7	100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,929,345.3	1,926,606.5	2,738.8	99.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	776,251.7	737,197.3	39,054.4	95.0
2104	Хангамж, бараа материалын зардал	325,938.3	320,066.2	5,872.1	98.2
2105	Нормативт зардал	53,365.9	53,316.8	49.1	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,166,372.9	2,166,133.5	239.4	100
2107	Томилолт, зочны зардал	128,721.6	128,443.2	278.4	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	681,131.3	678,471.4	2,659.9	99.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,452.1	93,431.7	20.4	100
211	ХҮҮ	-	-	-	-
212	ТАТААС	-	-	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	159,025.5	144,962.9	14,062.6	91.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	-	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,418,244.3	22,350,654.3	67,590.0	99.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,348,314.3	22,269,612.9	78,701.4	99.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	69,930.0	81,041.4	-11,111.4	115.9
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	-	-	-	-
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	3,812	3,824	-12	100.3
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	26	26	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,893	1,899	-6	100.3
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	-	-	-	-
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,893	1,899	-6	100.3

## 5. Хавсралт

### 5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Огноо:</b>	<b>Аудитын нэр:</b>	<i>Цаг уур, орчны шинжилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит</i>	
2019/03/23		<b>Аудитын код:</b>	САГ-2019/12/СТА- ТТЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	Цаг уур, орчны шинжилгээний газар		<b>сая төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл		Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	6
1	Тайлант онд эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт 2.8 сая төгрөгөөр тооцоо нийлсэн боловч санхүүгийн тайланд авлагаар тайлагнаагүй байна.	2.8	Зөвлөмж	2019 03.23	Нягтлан бодогч	Д.Отгонбаяр
2	Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх пуужингийн зарцуулалт 9ш пуужин буюу 3.7 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Пуужингийн зарцуулалтыг харвалтын тайлантай тулган шалгахад 9 пуужин харвасан акт дутуу байгаа нь Улаанбаатар хотын экспедицийн харвасан 6ш пуужингийн акт дутуу, зарим аймгууд шаардлага хангахгүй пуужинг үлдэгдлээр тоолдог, эсвэл зарцуулсанд тооцдог зэргээс 3ш пуужингийн зөрүү гарсан байна.	3.7	Зөвлөмж	2019 03.23	Дарга Нягтлан бодогч	С.Энхтүвшин Д.Отгонбаяр
Нийт		6.5				